



ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭ: МОНГОЛ УЛСЫН ВИЗ, ВИЗИЙН ЗӨВШӨӨРӨЛ БОЛОН ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭНД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ

2020 оны 12 сарын 31 –ний өдрийн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу Монгол улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль (2010) –ийг шинэчлэн найруулсан. Үүний дагуу Монгол улсын виз олгох журам, Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам болон Тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн баталсан байна.

Энэхүү хууль зүйн мэдээгээр Монгол Улсад хөрөнгө оруулах, хөдөлмөр эрхлэх болон түр ирэхтэй холбоотой зохицуулалтуудыг тусгайлан хүргэж байна.

I. Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл олгох

Энэхүү шинэчилсэн Журмаар Монгол улсын визийн ангиллууд болон цахим виз зэргийг шинээр зохицуулсан байна.

Визийн ангилал

	Визийн ангилал	Виз олгох гадаадын иргэн
Хөрөнгө оруулагчийн ангиллын виз	B1	➤ Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагч.
	B1-1	➤ Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчийн хамаарал бүхий этгээд.
	B2	➤ Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчийн төлөөлөгч, гүйцэтгэх удирдлагаар томилогдсон гадаадын иргэн.
	B2-1	➤ Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчийн төлөөлөгч, гүйцэтгэх удирдлагаар томилогдсон гадаадын иргэний хамаарал бүхий этгээд.
	B3	➤ Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын удирдлагаар ажиллах гадаадын иргэн.
	B3-1	➤ Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын удирдлагаар ажиллах гадаадын

		иргэний хамаарал бүхий этгээд.
Хөдөлмөр эрхлэгчийн виз	C1	➤ Барилга угсралт, зам, гүүр, бүтээн байгуулалтын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн.
	C1-1	➤ Барилга угсралт, зам, гүүр, бүтээн байгуулалтын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд.
	C2	➤ Шинжлэх ухаан, боловсрол, мэдээллийн технологийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн.
	C2-1	➤ Шинжлэх ухаан, боловсрол, мэдээллийн технологийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд.
	C3	➤ Геологи, уул уурхай, газрын тос, эрчим хүчний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн.
	C3-1	➤ Геологи, уул уурхай, газрын тос, эрчим хүчний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд.
	C4	➤ Санхүү, эдийн засаг, эрх зүйн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн.
	C4-1	➤ Санхүү, эдийн засаг, эрх зүйн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд.
	C5	➤ Соёл урлаг, спортын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн.
	C5-1	➤ Соёл урлаг, спортын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд
	C6	➤ Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн.
	C6-1	➤ Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд.
	C7	➤ Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн
	C7-1	➤ Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд.
	C8	➤ Эрүүл мэндийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн.
	C8-1	➤ Эрүүл мэндийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд.
	C9	➤ Хүмүүнлэгийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэн.
	C9-1	➤ Хүмүүнлэгийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэний хамаарал бүхий этгээд.
C10	➤ Өрхийн хэрэгцээнд зориулсан асаргаа, үйлчилгээний чиглэлээр ажиллахаар ирэх гадаадын иргэн.	
C11	➤ Тээврийн салбарт ажиллах болон экспортын ачаа тээвэрлэх гадаадын иргэн.	

Түр ирэх ангиллын виз	K1	➤ Ажил хэргийн шугамаар ирэх гадаадын иргэн.
	K2	➤ Жуулчлах зорилгоор ирэх гадаадын иргэн.
	K3	➤ Хил орчмын жуулчин.
	K4	➤ Соёл урлаг, спортын тэмцээн уралдаан, арга хэмжээнд оролцох, кино, контент бүтээхээр ирэх гадаадын иргэн.
	K5	➤ Импортын ачаа болон зорчигч тээвэрлэх гадаадын иргэн.
	K6	➤ Дамжин өнгөрөх гадаадын иргэн.
	K7	➤ Монгол Улсын олон улсын гэрээгээр тохиролцсоны дагуу харилцан адил нөхцөлөөр хөдөлмөр эрхлэх боломж бүхий богино хугацааны жуулчлалын хөтөлбөрт хамрагдан ирэх гадаадын иргэн.
	K8	➤ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахаар ирэх гадаадын иргэн.

Виз, визийн зориулалт, төрөл, хугацаа

Виз нь **орох, дамжин өнгөрөх** зориулалттай, **нэг, хоёр, олон удаагийн** гэсэн төрөлтэй байна. **Орох** зориулалтын визийг (1) **түр ирэгч¹**, (2) **хувийн хэргээр оршин суугч²**, болон (3) албан хэргээр оршин суугчид олгоно.

Түр ирэгч гадаадын иргэний Монгол Улсад байх нийт хугацаа тухайн жилд 180 хоногоос илүүгүй байх бөгөөд түүнээс илүү хугацаагаар байх тохиолдолд тус улсад **оршин суух зөвшөөрөл** авна.

№	Визийн төрөл	Хүчинтэй хугацаа /виз олгогдсон өдрөөс Монгол Улсын хилээр нэвтрэх хүртэлх хугацаа/	Байх хугацаа /Монгол Улсын хилээр нэвтэрснээс хойш тус улсад байх хугацаа/
1.	Нэг болон хоёр удаагийн “орох” виз	150 хоног	90 хүртэл хоног
2.	Олон удаагийн виз	183 эсхүл 365	30 хоног

Виз, визийн зөвшөөрөл олгох

Визийн зөвшөөрлийн хүчинтэй хугацаа олгогдсон өдрөөс хойш 60 хоног болж өөрчлөгдсөн.

¹ Монгол Улсад 90 хүртэл хоногийн хугацаагаар ирсэн гадаадын иргэн.

² Суралцах, **хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах**, гэр бүлийн шалтгаан болон хувийн бусад ажлаар оршин суухаар ирсэн гадаадын иргэн, түүний хамаарал бүхий этгээд.

Хөрөнгө оруулах, хөдөлмөр эрхлэх зорилгоор болон **түр ирэх** ангиллын **визийн зөвшөөрлийг** Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу “Гадаадын иргэн, харьяатын газар” (цаашид “ГИХГ” гэх) –аас авна. Хүсэлт гаргагч дараахь баримт бичгийг бүрдүүлсэн байх шаардлагатай. Үүнд:

1. Уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт;
2. Гадаадын иргэний паспортын хуулбар;
3. Хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах зорилгоор ирэх гадаадын иргэнд төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл;
4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын гэрчилгээний хуулбар;
5. Мэдүүлгийн хуудсыг бүрдүүлнэ.

Хөрөнгө оруулах зорилгоор визийн зөвшөөрөл мэдүүлэхэд дээрх баримт бичгээс гадна дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

- *гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан эсэх талаар харьяалах орны засаг захиргааны, эсхүл цагдаагийн байгууллагын тодорхойлолт, визийн зөвшөөрөл мэдүүлэгчийн сүүлийн 6 сарын дансны хуулга.*

Олон удаагийн виз, визийн зөвшөөрөл хүсэхэд дээрх баримт бичгээс гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

- Уригч аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээ;
- Гаалийн бүрдүүлэлт, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт зэрэг хилийн боомтоор олон удаа нэвтрэх шаардлагатайг нотлох баримт бичгийг бүрдүүлнэ.

Визийг Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, хилийн боомтод мэдүүлэх бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна:

1. Паспорт;
2. 3.5 см х 4.5 см хэмжээтэй 1 хувь цээж зураг;
3. Мэдүүлгийн хуудас;
4. Виз олгох эрх бүхий байгууллагаас олгосон визийн зөвшөөрөл, хувийн урилга;
5. Шаардлагатай бол албан хүсэлт;
6. Визийн хураамж төлсөн баримт.

Цахим виз олгох

- Дараах ангиллын визийг цахимаар олгох боломжтой болсон. Үүнд:
 1. К2 ангиллын виз буюу жуулчлах зорилгоор ирэх гадаадын иргэнд олгох виз;
 2. К4 ангиллын виз буюу соёл урлаг, спортын тэмцээн уралдаан, арга хэмжээнд оролцох, кино, контент бүтээхээр ирэх гадаадын иргэнд олгох виз;
 3. К6 ангиллын виз буюу дамжин өнгөрөх гадаадын иргэнд олгох виз.

- Цахимаар виз мэдүүлэгч нь визийн мэдүүлгийг бөглөн паспортын хуулбар, цээж зураг зэрэг шаардлагатай баримт бичгийг холбогдох системд оруулна. Цахим визийн мэдүүлгийг 3 хүртэл хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

Виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзах, хүчингүй болгох

- Виз, визийн зөвшөөрлийг олгохоос татгалзах шинэ үндэслэлүүдийг тогтоосон байна. Үүнд:
 1. Шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж өгөөгүй, баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, худал мэдүүлсэн нь тогтоогдсон;
 2. Виз, визийн зөвшөөрөл олгох үндэслэл тогтоогдоогүй;
 3. Гадаадын иргэнийг уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хуульд заасан үүргээ биелүүлээгүй;
 4. Эрх бүхий байгууллагын бичгээр ирүүлсэн саналыг харгалзан.
- Виз, визийн зөвшөөрлийг дараахь үндэслэлээр хүчингүй болгоно:
 1. Монгол Улсад орохыг үл зөвшөөрсөн хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд;
 2. Уригчийн үндэслэл бүхий хүсэлтийг харгалзан;
 3. Эрх бүхий байгууллагын бичгээр ирүүлсэн саналыг харгалзан;
 4. Визийн хуудас засвартай, бичилт, тэмдэглэгээ алдаатай;
 5. Албадан гаргаж байгаа;
 6. Визийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй олгосон;
 7. Баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, худал мэдүүлж виз авсан нь тогтоогдсон;
 8. Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн санал, дүгнэлт.
- Дахин хүсэлт гаргах хугацаанд дараах өөрчлөлт орсон:
 1. Шаардлагатай баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, худал мэдүүлсэн нь тогтоогдсон; болон
 2. Дээрх үндэслэлээр виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзсан, хүчингүй болгосон бол 180 хоногийн дараа хүсэлтээ дахин гаргаж болно.
 3. Бусад үндэслэлээр татгалзсан бол 30 хоногийн дараа хүсэлт гаргаж болно.

Гадаадын иргэн, уригч, ажил олгогч нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох хууль тогтоомжийг удаа дараа зөрчсөн тохиолдолд виз, визийн зөвшөөрөл олгохоос татгалзана.

Монгол Улсад байх хугацааг сунгах

- Түр ирэгч гадаадын иргэн Монгол Улсад байх хугацааг сунгуулах хүсэлтээ дараахь баримт бичгийг бүрдүүлэн уг хугацаа дуусахаас ажлын 5 –аас доошгүй хоногийн өмнө гаргана. Үүнд:
 1. Паспорт;
 2. Уригчтай бол уригчийн хүсэлт;
 3. Мэдүүлгийн хуудас.
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль зөрчиж, Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл хүлээсэн түр ирэгч гадаадын иргэний тухайн визийн байх хугацааг сунгахгүй.

Бусад

- Виз, визийн зөвшөөрөл олгох, сунгах хүсэлтийг ажлын 5 хоногт, яаралтай бол ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэнэ.
- Виз, визийн зөвшөөрөл мэдүүлэхэд паспортын хүчинтэй хугацаа 180 хоногоос доошгүй байна.

II. Монгол Улсад оршин суух

Монгол Улсад хөрөнгө оруулах /B/, хөдөлмөр эрхлэх /C/ зэрэг хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ гадаадын иргэн **Монгол улсын хил нэвтэрсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор** гаргана. Түр ирэгч гадаадын иргэн визийн ангилалдаа нийцсэн оршин суух зөвшөөрлийг мөн дурдсан хугацаанд мэдүүлж болно.

Бүрдүүлэх баримт бичиг:

1. Гадаадын иргэнийг Монгол Улсад урьсан болон уригчийн эрх, үүргийг хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага (цаашид “уригч” гэх) –ын оршин суух зөвшөөрөл хүссэн албан бичиг, өргөдөл;
2. Оршин суугаа хаягийн талаарх сум, хорооны Засаг даргын тодорхойлолт;
3. Паспорт, паспортын хуулбар;
4. Хамаарал бүхий этгээд оршин суух зөвшөөрөл хүсэхдээ гэрлэлтийн, төрсний үрчлэлтийн гэрчилгээ, эсхүл түүнийг баталгаажуулсан апостиль гэрчилгээ буюу консулын баталгаа, хамтран амьдрагчийг нотлох баримтыг баталгаат орчуулгын хамт;
5. Мэдүүлгийн хуудас;
6. 3.5 см х 4.5 см хэмжээтэй 1 хувь цээж зураг.

Шаардлагатай тохиолдолд дараах нэмэлт зүйлсийг шаардаж болно. Үүнд:

1. Эрүүл мэндийн шинжилгээ хийлгэхийг шаардах;
2. Ярилцлага хийх.

Оршин суух зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрөл этгээд	олгох	Зөвшөөрлийн хугацаа	Нэмэлтээр бүрдүүлэх баримт бичиг
Хөрөнгө оруулах	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагч		<ul style="list-style-type: none">➤ Эхний удаа 1 хүртэл жилээр олгох➤ Тухай бүр 3 хүртэл жилээр сунгах	<ul style="list-style-type: none">➤ <u>Татварын тодорхойлолт</u>
	<ul style="list-style-type: none">➤ Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчийн төлөөлөгч, гүйцэтгэх удирдлагаар томилогдсон гадаадын иргэн;➤ Гадаадын хуулийн этгээдийн		<ul style="list-style-type: none">➤ 1 хүртэл жилийн хугацаагаар олгох➤ Тухай бүр 1 хүртэл жилээр сунгах	

	төлөөлөгчийн газрын удирдлагаар ажиллах гадаадын иргэн;		
	Хөрөнгө оруулах зорилгоор оршин суух гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгоход харгалзан үзэх шалгуур: <ul style="list-style-type: none"> ➢ Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний эрх олгосон байгууллагын хүсэлт; ➢ Монгол Улсын иргэнийг ажлын байраар хангасан байдал; ➢ Татвар төлөлт; ➢ Үйл ажиллагааны тогтворжилт; ➢ Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон гэрчилгээ; ➢ Шаардлагатай тохиолдолд, гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн санал. 		
Хөдөлмөр эрхлэх	➢ Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл бүхий гадаадын иргэн	➢ 1 хүртэл жилээр олгох ➢ Тухай бүр 1 хүртэл жилээр сунгах	➢ Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл
Түр ирэх	Ажил хэргийн шугамаар түр ирэгч гадаадын иргэнд дараах төрлөөр оршин суух зөвшөөрөл олгож болно. <ul style="list-style-type: none"> ➢ В1; ➢ В2; ➢ В3; ➢ Инновацийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх гадаадын иргэн /E5/. 		

Оршин суух зөвшөөрөл олгох, сунгах хүсэлтийг ажлын 5 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Ийнхүү зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзсан тохиолдолд тухайн иргэн шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор Монгол Улсаас сайн дураараа гарах ёстой.

Оршин суух зөвшөөрлийн бүртгэлээс хасалт хийлгэх

Монгол Улсаас бүрмөсөн гарах, оршин суух зөвшөөрлийн хугацаанд буцаж ирэхгүй, оршин суух хэлбэр, төрлөө өөрчилсөн зэрэг тохиолдолд хамаарал бүхий этгээдийн хамт оршин суух зөвшөөрөл олгосон байгууллагад оршин суух үнэмлэхээ хураалгаж, оршин суух зөвшөөрлийн бүртгэлээс хасалт хийлгэнэ. Оршин суух зөвшөөрлийн хугацаа дууссан өдрөөс хойш 10 хоногийн дотор Монгол Улсаас гарна.

Дараахь тохиолдолд гадаадын иргэнийг уригч нь оршин суух зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэнэ:

1. Оршин суух хэлбэр, төрлөө өөрчилсөн;
2. Гадаадын иргэн албан тушаал, ажлын байраа өөрчилсөн, орхисон, чөлөөлөгдсөн;
3. Гадаадын иргэн хууль тогтоомж зөрчсөн;
4. Гадаадын иргэн нас барсан, сураггүй алга болсон.

III. Тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээ

	Үйлчилгээний төрөл	Хэмжээ
1.	Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгох	120 000 төгрөг
2.	Монгол Улсад оршин суух үнэмлэх олгох, солих	15 000 төгрөг
3.	Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгах	72 000 төгрөг
4.	Гадаадын иргэнд хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгох	3 000 төгрөг
5.	Оршин суух үнэмлэхэд оршин суугаа хаягийн өөрчлөлт, бусад тэмдэглэл хийх	Тухай бүрт 2 500 төгрөг
6.	Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгох	10 000 төгрөг
7.	Гадаадын иргэний талаар тодорхойлолт гаргах	2 500 төгрөг
8.	Оршин суух болон зорчих үнэмлэх шинээр буюу дахин олгох	36 000 төгрөг
9.	Визийн зөвшөөрөл олгох	2 500 төгрөг
10.	Нэг удаагийн орох виз олгох	45 ам.доллар
11.	Хоёр удаагийн орох виз олгох	60 ам.доллар
12.	Зургаан сарын олон удаагийн виз олгох	100 ам.доллар
13.	Зургаан сараас нэг жил хүртэлх хугацаагаар олон удаагийн виз олгох	200 ам.доллар
14.	Визийн хугацааг долоо хүртэл хоногоор сунгах	40 000 төгрөг <i>Дараагийн хоног тутамд 5 600 төгрөг</i>
15.	Визийн ангилал өөрчлөх	36 000 төгрөг
16.	10-13 –д заасан визийн үйлчилгээ үзүүлэх	5 ам.доллар
17.	1-16 –д заасан үйлчилгээг яаралтай буюу хилийн боомт дээр үзүүлэх	Хураамжийн хэмжээ хоёр дахин нэмэгдэнэ.

18.	Биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ) – ийн бүртгэлд бүртгэх	5 ам.доллар
-----	----------------------------------------------------------------------	-------------

Эх сурвалж:

1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль (2010):
<https://legalinfo.mn/main/detail/211>
2. Монгол Улсын виз олгох журам (2021):
<https://legalinfo.mn/main/detail/16230721355601>
3. Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам (2021): <https://legalinfo.mn/main/detail/16230721395541>
4. Тэмдэгтийн хураамж, визийн үйлчилгээний хөлсний хэмжээ (2021):
<https://legalinfo.mn/main/detail/16231084392271>

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, GRATA International Хуулийн Фирмийн партнер В.Болормаатай bvolodya@gratanet.com эмайл болон эрх зүйч Т.Буянжаргалтай btungalag@gratanet.com эмайлээр эсхүл +976 70155031 утсаар холбогдоорой.